

ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ.

3.1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Өнгөрсөн 2010 онд салбарын төсвийн ерөнхийлөн захирагч сайдуудтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг улирлаар тооцон дүгнэж ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтийг яамдын сайд тус бүрээр нь дүгнэвэл:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 3 зорилт, 40 бүтээгдэхүүнийг 89.4 хувиар биелүүлж, 796.6 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

2. Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний дагуу 4 зорилт, 18 бүтээгдэхүүнийг 98.1 хувиар биелүүллээ.

3. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 4 зорилт, 17 бүтээгдэхүүнийг 92.6 хувиар биелүүлж, 5814.2 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

4. Байгаль орчны сайдтай байгуулсан гэрээний дагуу 4 зорилт, 5 бүтээгдэхүүнийг 94.0 хувиар биелүүлж, 494.5 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

5. БСШУ-ны сайдтай байгуулсан гэрээний дагуу 6 зорилт 63 бүтээгдэхүүнийг 93.6 хувиар биелүүлж, 13126.0 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

6. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээний дагуу 5 зорилт, 41 бүтээгдэхүүнийг 93.9 хувиар биелүүлж, 229.4 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

7. ХХААХҮ-н сайдтай байгуулсан гэрээний дагуу 5 зорилт, 19 бүтээгдэхүүнийг 89.8 хувиар биелүүлж, 594.4 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

8. Үндэсний статистикийн газрын даргатай байгуулсан гэрээний дагуу 4 зорилт, 41 бүтээгдэхүүнийг 100 хувиар биелүүлж, 30.1 сая төгрөгөөр санхүүжигдлээ.

9. Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу Хүүхдийн байгууллага 4 зорилт 8 бүтээгдэхүүнийг 90 хувиар биелүүлж, 188.9 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ.

10. Тэргүүн Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу Стандарт хэмжил зүйн төв 4 зорилт, 223 бүтээгдэхүүнийг 100 хувиар биелүүлж, 51.7 сая төгрөгийн санхүүжилт хийгджээ.